



## БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/45/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: <a href="mailto:tseenyma@audit.gov.mn">tseenyma@audit.gov.mn</a> Аудитор: Г.Ганчимэг Утас:88268424 Цахим хаяг: <a href="mailto:ganaa_7133@yahoo.com">ganaa_7133@yahoo.com</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

Аудитын гэрчилгээ .....	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго: .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	8
2.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.14 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	10
2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	16
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	17
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	23

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail: bayankhongor@audit.gov.mn

᠒᠐2᠐.᠐᠗.27 № 1182

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Аудитын гэрчилгээ Г

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН ТҮҮХ  
УГСААТНЫ ЗҮЙ, БАЙГАЛИЙН МУЗЕЙН  
ЗАХИРАЛ А.МАНДАХ ТАНАА Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Аудитын гол асуудал**

Гүйцэтгэсэн горим сорилын дүнд илэрсэн алдаа, зөрчлийн дүн нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшингээс хэтэрсэн.

Аймгийн ИТХ, ЗДТГ-аас Орон нутгийн музейн үзмэрийн хамгаалалт хийлгэхээр 2200,0 мянган төгрөг олгосныг зориулалт бусаар зарцуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020136

Музейн үзмэрийг орлого авах тушаал гаргахдаа үнийн дүнг зөрүүтэй гаргасан, нягтлан бодогч 320,0 мянган төгрөгийн 3 үзмэрийг орлогод дутуу бүртгэсэн.

Өмнөх оны аудитаар буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр тогтоосон актын төлбөр 1062,3 мянган төгрөгийг төсвөөс төлсөн.

Төсвөөс 819.6 мянган төгрөгөөр урилга, цаасан тор хийлгэж байгууллагын ой тэмдэглэх арга хэмжээнд зарцуулсан, мөн хүчин төгөлдөр бус гэрээ үндэслэн 2900,0 мянган төгрөгийг шилжүүлж аудитын явцад нөхөж бичсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", ЗГ-ын 2014 оны "Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээ"-ний тухай 147 дугаар тогтоолын 4-д "...төсөвт байгууллага, төв орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсвийн хөрөнгөөр олон нийтэд зайлшгүй мэдээлэх хууль, тогтоомж, албан ёсны шийдвэр болон тэдгээрийн хэрэгжилтийг сурталчлан таниулахаас бусад зорилгоор өөрийн байгууллага, хамт олныг рекламдах,... баяр, ёслол, байгууллагын ой, тэмдэглэлт өдөр зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын..., зүйлс бэлтгэх ивээн тэтгэхийг хориглосугай". гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Дээрх алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн толилуулгын Үнэн зөв, Оршин байх, Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэлгээ, Хэмжилт, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

## Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал А.Мандах танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.22-аас 2020.02.26-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.27-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.02.20-ний өдөр, аудит хийлгэх хүсэлтээ 2020.01.09-ний өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### 2.4. Байгууллагын зорилго:

Соёлын үйлчилгээ, музейн үйл ажиллагааны хүртээмжийг дээшлүүлж, Монгол зан заншил уламжлалаа хүүхэд залууст өвлүүлэн уламжлуулах нийгмийн хөгжлийн түүхийг баримтжуулан хамгаалах үйлчилгээний шинэ хэлбэрийг нэвтрүүлэн иргэдийн соёлын биет болон биет бус өвийн мэдлэгийг дээшлүүлж, танин мэдэхүй мэдээлэл сургалт сурталчилгааны төв болоход оршино.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бүс нутгийн хэмжээний төв халхчуудын түүх,өв уламжлал,ёс заншлын гол цөм болохын хувьд түүх соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх түшиц газар болон хөгжихийн төлөө үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашиглаж байна.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 35 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 17 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин-г “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 219528,1 мянган төгрөгөөс тооцон 4390,5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин-г үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнгийн 2% буюу 4390,5 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 281825,6 мянган төгрөгөөр буюу 18,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	1	2	3=2-1
<b>Б</b>			
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	1,187.70	1,187.70	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	20,580.30	24,334.70	3,754.40
Үндсэн хөрөнгө	1,511,328.30	1,793,153.90	281,825.60
Хуримтлагдсан элэгдэл	(103,187.40)	(117,250.50)	(14,063.10)
Нийт хөрөнгө	1,429,908.90	1,701,425.80	271,516.90
Өр төлбөр	739.40	-	(739.40)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,429,169.50	1,701,425.80	272,256.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,429,908.90	1,701,425.80	271,516.90

Авлага дансны үлдэгдэлд 2005 онд үүссэн он удаан жил болсон 1187,7 мянган төгрөгийн байгууллагаас авах авлага байна. Энэ нь тухайн үед харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулаагүй шалтгааны улмаас барагдах боломжгүй найдваргүй авлага үүсээгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3754,4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хийлгэсэн зургийн цомог, ойд зориулж хийлгэсэн байгууллагын түүхэн номын тооцоог хийж зарлага гаргаагүйтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 281825,6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 15992,6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан аймгийн ИТХТ-ын 2019.04.26 ний өдрийн 56 дугаар тогтоолоор Галуут сумын соёлын төвийн үндсэн хөрөнгөд

бүртгэлтэй 255817,0 мянган төгрөгийн балансын өртөгтэй “Буян арвидах” хийдийг балансаас баланс-д шилжүүлж авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн болон биет бус хөрөнгийн дансанд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөрийн дансны өмнөх оны 739,4 мянган төгрөгөөр байгууллагад төлөх өглөгийг бүрэн барагдуулж тайлант онд өр төлбөр үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1701425,8 мянган төгрөг болж 272256,3 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлт нь тайлант үеийн үр дүнгийн зардал байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй дахин үнэлгээний дансанд өөрчлөлт ороогүй байна.

## **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн тайлант онд үндсэн үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 2 зориулалтад 210916,9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 210916,9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 210916,9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 210916,9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Зардлыг санхүүжүүлэх орлогын 210916,9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгожээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 209782,7 мянган төгрөг буюу 99,5 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 90,2 мянга, тогтмол зардлаас 142,7 мянга, хангамжийн материалын зардлаас 446,2 мянга, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас 446,1 мянган төгрөгийг хэмнэж зарцуулаагүй үлдэгдэл 1134,1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлснээс шалтгаалжээ.

**Нэмэлт төсөв:** Дээд шатны төсөв захирагчаас буюу аймгийн ИТХ, ЗДТГ, БСУГ-аас үзмэрийн тооллогын зардал, музейн үзмэр худалдаж авах зардал, шилэн хорго хийлгэх гэх мэт зардалд 5820,0 мянга, хандив тусламжаар 1420,0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 4619,5 мянга нийт 11859,5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн. Үүнээс зарцуулаагүй үлдэгдэл 997,7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

## **2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 7 чиглэлээр аудитын 29 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 20 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитаар нийт 54370,0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1130,0 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 53240,0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 54370,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1130,0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож хүргүүлээ. Үүнд:

#### **1. Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн**

2018 оны санхүүгийн тайлангаар аудитаар тогтоосон ажиллагсдад илүү олгосон 106.3 мянган төгрөгийн цалинг суутгаагүй, төсөв захирагч, нягтлан бодогч нарт хариуцуулж төлүүлэхээр ноогдуулсан гэрэл цахилгаан, шуудан холбооны зардлаас илүү төлсөн 956.0 мянган төгрөгийг төсвөөс төлж, санхүүгийн тайланд шууд зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтуудад зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:**Төлбөрийн акт тогтоох.

#### **2.Цалингийн зардал.**

Цалингийн зардлыг цалингийн цэст болон ерөнхий дэвтэр,журналаас түүвэрлэн шалгахад Б.Отгонтунгалагийн амралтын цалингийн 413.6 мянган төгрөгөөс татвар, шимтгэлийн 83.2 мянган төгрөгийг суутган тооцоогүй бодогдсон цалинг олгосон. Мөн Д.Ганбаатарт 10-р сард 216.0 мянган төгрөгийн цалин бодож холбогдох суутгалыг хийж олгосон боловч Нийгмийн даатгалын хэлтэс-т цалингийн санг мэдээлээгүйгээс шимтгэлийн 51.8 мянган төгрөгийг төлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1/1-д “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх”, 32 дугаар зүйлийн 1/1-т “Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна”, гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:**Төлбөрийн акт тогтоох.

#### **4. Санхүүгийн тайлан дүгнэлттэй холбоотой**

Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт Аймгийн ИТХ, ЗДТГ-аас Орон нутгийн музейн үзмэрийн хамгаалалт хийлгэхээр 2200,0 мянган төгрөг олгосныг зориулалт бусаар зарцуулсан.

Музейн үзмэрийг орлого авах тушаал гаргахдаа үнийн дүнг зөрүүтэй гаргасан, нягтлан бодогч 320,0 мянган төгрөгийн 3 үзмэрийг орлогод дутуу бүртгэсэн.

Өмнөх оны аудитаар буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр тогтоосон актын төлбөр 1062,3 мянган төгрөгийг төсвөөс төлсөн.

Төсвөөс 819.6 мянган төгрөгөөр урилга, цаасан тор хийлгэж байгууллагын ой тэмдэглэх арга хэмжээнд зарцуулсан, мөн хүчин төгөлдөр бус гэрээ үндэслэн 2900,0 мянган төгрөгийг шилжүүлж аудитын явцад нөхөж бичсэн, аудитаар илэрсэн алдааны дүн урьдчилж тогтоосон материаллаг байдлын дүнгээс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, Төрийн аудитын тухай хуулийн 28.1-т заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах саналыг сумын Засаг дарга Ж.Хатанбаатар хүргүүлэв.

**Шийдвэрлэсэн:** Албан шаардлага өгөв.

**2.12 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын явцад ойн арга хэмжээний орлого зарлага, кассаар хүлээж авсан заалны орлого болон нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлэн зарцуулж буй орлого, зарлага, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн үлдэгдлийг гүйцээж мөшгин шалгаж тулган баталгаажуулах цаг хугацааны боломжгүйгээс үзээгүй болно.

**2.13 Шилэн дансны мэдээлэл:**

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн төсвийн гүйцэтгэлийг 12 сард, төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар бүтэн жилээр, өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлбар, тус тус бүтэн жилээр, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг тус бүр 12 сард мэдээлээгүй. Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ хоцроож мэдээлсэн. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	6	1	4
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	33		3
5	Тухай бүр	8	96	96		
6	Нийт	27	151	143	1	7

**2.14 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар албан хаагчдын цалингийн зардалтай холбоотой 106,3 мянга, төсвийг зориулалт бусаар зарцуулалттай холбоо 956,0 мянган төгрөгийн төлбөрийн акт гарсны тайлант хугацаанд бүрэн барагдуулсан боловч хууль тогтоомж зөрчиж төсвийн хөрөнгөөр барагдуулж зөрчлийг давтан гаргасан байна.

**2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

**“Хязгаарлалттай” дүгнэлт**

Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүй-байгалийн музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалт, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### **Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### **3.1 Төсөв гүйцэтгэлтэй холбоотой**

#### **3.1.1 Илрүүлэлт:**

Тайлант онд байгууллагын 70 жилийн ойг тэмдэглэх өнгөрүүлэхтэй холбоотой хувь хүмүүсээс 1420,0 мянган төгрөгийн бэлэн мөнгө, 10616,0 мянган төгрөгийн үзмэрийг хандиваар авч Музейн захирлын 2019.12.31 өдрийн А/06 тоот тушаалаар 134 дэс, 143 ширхэг үзмэрийн дүн 14287.0 мянган төгрөг байхад тушаалыг 599.4 мянган төгрөгөөр дутуу буюу зөрүүтэй гаргасан. Мөн нягтлан бодогч үзмэрийг бүртгэлд тусгахдаа 320.0 мянган төгрөгийн 3 ш үзмэрийг дутуу орлого авсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **3.1.2 Эрсдэл**

Тайлант хугацаанд бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламжийг нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэлд бүрэн тусгаагүй нуун дарагдуулсан байх, зориулалт бусаар зарцуулсан байх.

#### **3.1.3 Өгсөн зөвлөмж**

Байгууллагын дансанд бусад байгууллага, иргэдээс өгсөн хандивын орлогыг Төрийн сангийн төлбөр тооцооны журмын дагуу харилцах дансанд тухай бүр төврүүлэн, хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж хөрөнгийн орлогыг анхан шатны баримт, холбогдох тушаал шийдвэрийн дагуу дансанд бүрэн тусгаж, авлагыг бүрэн барагдуулан цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

**3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

### **3.2 Төсвийн зарцуулалт**

### **3.2.1 Илрүүлэлт:**

Байгууллагын ойг тэмдэглэх ажлын хүрээнд "Мөнхийн үсэг" ХХК-тай 2019.05.27 ний өдөр нэг бүрийн 12700 төгрөгөөр 500 ширхэг зургийн цомог 6350.0 мянган төгрөгөөр хийлгэх гэрээг байгуулж, бусад бараа үйлчилгээний зардлаас тушаал, шийдвэргүй 2019.07.01 ний өдөр 4445.0 мянган төгрөг төлсөн ба нягтлан бодогч орлого авахдаа 600 ш зургийн цомгийг нийт 7620,0 мянган төгрөгөөр орлого авч, дутуу төлсөн 3175,0 мянган төгрөгийг тайланд бэлэн мөнгөний орлогоор хүлээн зөвшөөрч дансанд буруу бүртгэсэн байна.

Мөн Соёмбо принтинг ХХК-тай 2019.05.30 ний өдөр 2250.0 мянган төгрөгөөр "130 ш нэг бүр 14000 төгрөгийн ном, 200 ш нэг бүрийн 2150 төгрөгийн цаасан тор хийлгэх" гэрээ байгуулж, нэмэлт санхүүжилтийн данснаас 2019.12.05 ний өдөр 2250.0 мянган төгрөгийг шилжүүлж ойн арга хэмжээнд зарцуулсан мөн 389.6 мянган төгрөгөөр урилга хийлгэж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. дээрх хөрөнгүүдийг хүлээж авсан комиссын акт байхгүй, ойн арга хэмжээнд зарцуулсан байхад үлдэгдлээр тайлагнаж, жилийн эцсийн тооллогоор бэлэн байгаар тоолсон, нягтлан бодогч тооллогын тооцоог бодоогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" 5.1.5-т "хэмжигдэхүйц байх", 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", ЗГ-ын 2014 оны "Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээ"-ний тухай 147 дугаар тогтоолын 4-д "...төсөвт байгууллага, төв орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсвийн хөрөнгөөр олон нийтэд зайлшгүй мэдээлэх хууль, тогтоомж, албан ёсны шийдвэр болон тэдгээрийн хэрэгжилтийг сурталчлан таниулахаас бусад зорилгоор өөрийн байгууллага, хамт олныг рекламдах,.... баяр, ёслол, байгууллагын ой, тэмдэглэлт өдөр зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын зүйлс, цүнх календарь зэрэг зүйлс бэлтгэх ивээн тэтгэхийг хориглосугай". гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

### **3.2.2 Эрсдэл**

Үнэн зөв, эрх үүрэг батламж мэдэгдэл хангагдахгүй байх, санхүүгийн анхан шатны бүртгэлд тавих хяналт сул байх, хөрөнгө шамшигдах, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх.

### **3.2.3 Өгсөн зөвлөмж**

Хөрөнгийн тооллогыг дахин зохион байгуулж, үр дүнг хэлэлцэж, хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулж, нягтлан бодох бүртгэлд тусгах. Цаашид хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналтыг сайжруулах, төсвийн хөрөнгөөр байгууллагын ой, тэмдэглэлт баяр, гэх мэт зардлыг санхүүжүүлдэг явдлыг зогсоож Засгийн газрын 2014 оны "Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээ"-ний тухай 147 дугаар тогтоолын 4-дэх заалтыг мөрдөж ажиллах.

**3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан бөгөөд хүлээн зөвшөөрсөн болно.

## **3.3 Төсвийн төлөвлөлт**

**3.3.1 Тайлант оны төсвийн гүйцэтгэлийг тогтоолтой тулган шалгахад тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 8534.4 мянган төгрөг батлагдсан байна. Дээрх зардал нь үзмэр харагч, үйлчлэгч А.Гантулгын тэтгэвэрт гарах тэтгэмжийг суулгасан боловч тэтгэвэрт тогтоолгох нас хүрээгүй учраас тэтгэмжийн зардлыг олгоогүй.**

Аймгийн ЗД-ын төсөвт зохицуулалт хийх тухай 2019.12.16 өдрийн А/645 тоот захирамжаар бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулахаар зохицуулалт хийлгэсэн

боловч төсвийн хэлбэлзэл дээр бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээний зардлын төлөвлөгөө нь дээр тавьж тоног, төхөөрөмж, үзмэр худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан.

Мөн аймгийн ИТХ-аас 1100.0 мянга, ЗДТГ-аас 1100.0 мянган төгрөгийг "Хүндэтгэлийн булан шилэн хорго" хийлгэх зардлын санхүүжилтийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн боловч Дээрх зардлыг зориулалтын дагуу зарцуулаагүй байгууллагын болон ойн үйл ажиллагаанд зарцуулж, төсвийн урсгал засварын зардлаас 2531.7 мянган төгрөгөөр 2 шилэн хорго, хийлгэж дээд шатны төсөв захирагчийн олгосон санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан зөрчлүүд илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтууд зөрчсөн байна.

### **3.3.2 Эрсдэл**

Хууль, журам хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах, төсвийн сахилга бат алдагдах.

### **3.3.3 Өгсөн зөвлөмж**

